



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 133

Мандалговь


Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018, 2021 онуудад барьж ашиглалтад оруулсан нийт 234 931 090 (хоёр зуун гучин дөрвөн сая есөн зуун гучин нэгэн мянга ерэн) төгрөгийн төсөвт өртөгтэй цахилгаан хангамжийн барилга байгууламжийг хавсралтын дагуу мэргэжлийн байгууллага болох “Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХКомпанийн харьяа “Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбар”-ын өмчид шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон цахилгаан хангамжийн барилга байгууламжийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохих хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д даалгасугай.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.



ДАРГА **С.ОД-ЭРДЭНЭ**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын
23-ний өдрийн 133 тогтоолын хавсралт

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар
хийгдсэн цахилгаан хангамжийн барилга байгууламжийн жагсаалт

№	Барилга байгууламжийн нэр	Төсөвт өртөг/төгрөг/
1	Сайнцагаан сумын Цэнгэлдэх хүрээлэнгийн цахилгаан хангамж /2018 он/	43 569 970
2	Сайнцагаан сумын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж /2018 он/	122 239 853
3	Луус сумын 0,4 кв цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл /2021 он/	69 121 267
Нийт дүн		234 931 090 /хоёр зуун гучин дөрвөн сая есөн зуун гучин нэгэн мянга ерэн төгрөг/